

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.НАРАНЦОГТ ТАНАА

2019.02.25 № 06/212
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сангийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сангийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сангийн яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Сангийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сангийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сангийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 09-нээс 2019 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Уянга нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сангийн яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11-2/372 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сангийн яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүү, эдийн засгийн оновчтой удирдлагаар хангахад оршино.

Сангийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Санхүү, эдийн засаг, төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүү, эдийн засгийн шинэчлэл, зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах;
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;
- Санхүүгийн хамтын ажиллагаа, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, зохицуулалтыг сайжруулах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх

Сангийн яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Сангийн яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Сангийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сангийн яам санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Сангийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сангийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг, өөрийн орлого бүрдүүлдэггүйтэй холбоотой юм.

Сангийн яамны 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,385,035.8 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 487,700.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь эрсдэл бага байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 6 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 168,196.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 149,092.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 19,104.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	19,104.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	-	-	
3	Албан шаардлага өгсөн	-	-	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	-	-	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	-	-	
Дүн		2	19,104.3	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон 1,726.0 мянган төгрөгийн урамшуулал, 3,490.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг дутуу тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

2. Газрын дахин үнэлгээний дүн 19,557.5 мянган төгрөгөөр засгийн газрын санг нэмэгдүүлээгүй, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд буруу бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

3. Балансаас балансад шилжүүлсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассанаас үүссэн 11,326.4 мянган төгрөгийн гарзыг тайлант хугацааны элэгдлийн зардалд тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

4. Тайлант онд ашигласан 17,946.0 мянган төгрөгийн 1 жилийн хугацаатай антивирус болон хамгаалалтын програм, 7,497.6 мянган төгрөгийн зарцуулсан сүлжээний утас нийт 25,443.6 мянган төгрөгийн материалыг зардалд тусгаагүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

5. Малын насжилтыг буруу тооцоолсноос бараа материалын үлдэгдлийг 1,010.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

6. Програмын 85,807.0 мянган төгрөгийн жилийн урьдчилгаа үйлчилгээний төлбөрийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

7. Цалингийн тооцооллыг буруу хийснээс илүү олгосон 732.1 мянган төгрөгийн цалинг ажиллагсдаас авах авлагаар бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сангийн яам 2018 онд улсын төсвөөс урсгал зардалд олгосон санхүүжилтээс 1,852,935.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсаныг Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлд хийх аудитаар шалтгааныг төлөвлөлттэй нь уялдуулан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сангийн яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 14,464,319.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Урсгал төсвийн зардлын нийт гүйцэтгэл 10,959,337.1 мянган төгрөг буюу 75.8 хувьтай байгаа нь 1,655,503.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон, 1,852,935.7 мянган төгрөг дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Жилийн эцэст дутуу зарцуулсан санхүүжилтийн үлдэгдэл 1,852,935.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт 16,000,000.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 11,759,452.8 мянган төгрөг олгосон байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Сангийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сангийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сангийн яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Хэрэгцээ шаардлага хангахгүй болсон 17,789.6 мянган төгрөгийн хангамжийн материалыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн байгууллагын удирдлагын тушаалгүйгээр данс бүртгэлээс хассан нь ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.5-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж, данснаас хасах асуудлыг өмч хамгаалах зөвлөл судлан дүгнэлт гаргах бөгөөд хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар шийдвэрлэнэ. Өмч хамгаалах зөвлөл шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгө алдагдах, шамшигдах эрсдэл

1.3. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн байгууллагын удирдлагын тушаал гаргуулж хангамжийн материалыг данс бүртгэлээс хасаж байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг дагуу ажиллахаа илэрхийлсэн.

2. *Зардлын данстай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Гадаад томилолтын зардлаас ерөнхий сайдын албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд ороогүй 2 сэтгүүлчийн 1,314.7 мянган төгрөгийн зардлыг тушаал шийдвэргүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, тушаал шийдвэрийг гаргаж зарцуулж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг дагуу ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>484,018,158.02</u>	<u>2,382,235,018.11</u>
33	АВЛАГА	200,012,814.92	1,282,092,374.31
335	Бусад авлага	200,012,814.92	1,282,092,374.31
3351	Байгууллагаас авах авлага	199,131,414.72	1,280,890,717.03
3352	Хувь хүмүүсээс авах авлага	881,400.20	1,201,657.28
34	УРЬДЧИЛГАА	36,829,850.00	665,111,451.34
34600	Урьдчилж гарсан зардал	36,829,850.00	665,111,451.34
35	БАРАА МАТЕРИАЛ	247,175,493.10	435,031,192.46
354	Хангамжийн материал	214,265,493.10	398,841,192.46
35410	Бичиг хэргийн материал	7,755,400.00	12,931,200.00
35420	Аж ахуйн материал	200,213,338.10	379,448,628.46
35440	Түлш, шатах тослох материал	6,296,755.00	6,461,364.00
35600	Мал амьтад	32,910,000.00	36,190,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,345,713,746.29</u>	<u>14,373,366,561.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,345,713,746.29	14,373,366,561.29
392	Биет хөрөнгө	7,364,665,021.24	11,277,965,242.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,174,036,056.16	8,002,876,326.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-590,693,101.77	-145,950,019.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	337,667,682.00	427,513,623.81
39204	Хуримтлагдсан элэгдэл	-87,933,513.30	-122,808,095.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,025,322,257.80	7,513,355,966.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,779,790,267.22	-4,729,915,191.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	732,809,588.50	822,994,264.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-447,886,680.93	-494,308,435.30
39217	Ном	1,133,000.00	4,206,804.00
393	Биет бус хөрөнгө	2,981,048,725.05	3,095,401,319.00
39301	Программ хангамж	3,483,356,619.93	3,844,782,820.86
39302	Хуримтлагдсан элэгдэл	-502,307,894.88	-768,939,021.86
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	19,557,520.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,829,731,904.31</u>	<u>16,755,601,579.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,874,000.00</u>	<u>449,090.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,874,000.00	449,090.90
413	Өглөг	2,874,000.00	449,090.90
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,874,000.00	449,090.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10,826,857,904.31</u>	<u>16,755,152,488.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,826,857,904.31	16,755,152,488.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,933,084,087.17	5,952,641,607.17
51101	Өмч: - төрийн	5,933,084,087.17	5,952,641,607.17
512	Хуримтлагдсан үр дүн	4,818,810,673.28	7,417,749,785.17
51210	Өмнөх үеийн үр дүн	4,818,810,673.28	4,818,810,673.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,598,939,111.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,963,143.86	3,384,761,096.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10,829,731,904.31</u>	<u>16,755,601,579.40</u>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл 2016.12.31	Тайлант оны гүйцэтгэл 2017.12.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,032,562.00	1,667,058,615.91
120	Нийтлэг татварын бус орлого	217,711,000.00	1,667,058,615.91
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	217,090,000.00	1,666,592,734.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,725,972.67
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	217,090,000.00	1,664,866,762.24
120009	Бусад орлого	621,000.00	465,881.00
122	Тусламжийн орлого	9,321,562.00	-
122002	Хандив тусламж /гадаад/	9,321,562.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,267,619,370.00	25,316,916,258.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,087,548,200.00	24,072,455,373.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,036,174,200.00	12,808,816,800.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,874,000.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	48,500,000.00	11,263,638,573.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,071,170.00	1,244,460,885.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	114,622,280.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУ-ын байгууллага	174,631,670.00	-
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	104,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	-	1,022,478,605.31
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,439,500.00	3,260,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	14,147,054,271.11	24,353,418,993.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,098,554,271.11	13,142,860,420.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,564,335,634.21	8,847,796,852.12
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,420,691,150.84	2,251,612,392.75
210101	Цалин	2,420,691,150.84	2,251,612,392.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	281,554,609.95	278,309,550.89
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	182,790,851.15	187,406,916.72
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	24,527,854.72	23,187,991.47
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	20,295,995.49	18,241,285.79
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	4,903,628.69	4,464,827.73
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	49,036,279.90	45,008,529.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,691,464.01	170,679,025.80
210301	Гэрэл цахилгааны зардал	73,983,575.01	115,337,858.80
210302	Түлш, халаалтын зардал	39,316,608.00	29,298,702.00
210303	Цэвэр, бохир усны зардал	7,701,281.00	6,277,215.00

Сангийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210304	Байрны түрээс	61,690,000.00	19,765,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,066,838.46	238,300,461.04
210401	Бичиг хэргийн материал	45,661,890.00	59,241,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	19,402,527.80	25,386,155.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	31,004,999.10	33,983,955.00
210404	Ном, хэвлэлийн зардал	4,268,950.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	19,254,350.00	1,565,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	21,394,121.56	118,124,051.04
210408	Бараа материал акалсны зардал	80,000.00	-
2105	Нормативт зардал	40,400.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,533,180.00	12,265,235.00
210601	Багаж хэрэгсэл	-	2,258,400.00
210604	Урсгал засвар	11,533,180.00	10,006,835.00
2107	Томилолт, зочны зардал	131,767,720.04	64,537,121.00
210702	Дотоод томилолтын зардал	69,688,344.95	31,644,169.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	62,079,375.09	32,892,952.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,537,032,486.87	3,727,828,308.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,532,377,846.87	3,659,016,715.68
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,651,820.00	4,985,516.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	483,820.00	571,833.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	121,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	2,475,000.00	63,040,226.86
210807	Газрын төлбөр	-	93,016.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,857,957,784.04	2,104,264,757.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,891,528,003.23	628,564,242.81
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	126,580,750.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	839,849,030.81	1,475,700,514.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,534,218,636.90	4,295,063,568.69
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	623,606,615.96	2,100,552,808.66
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	623,606,615.96	2,100,552,808.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,719,967.89	341,575,048.34
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	127,919,967.89	144,075,048.34
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	58,800,000.00	197,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,723,892,053.05	1,852,935,711.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,723,892,053.05	1,852,935,711.69
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,500,000.00	11,210,558,573.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,500,000.00	11,210,558,573.00
220001	Барилга байгууламж	48,500,000.00	11,210,558,573.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	4,347,597,660.89	2,630,555,880.41
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,639,848,615.63	31,616,768.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	127,372,372.21	22,436,768.52
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	9,180,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	2,512,476,243.42	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-2,639,848,615.63	-31,616,768.52
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1,707,749,045.26	2,598,939,111.89

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	19,819,359,695.88	25,320,256,139.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	621,000.00	3,339,881.00
120	Нийтлэг татварын бус орлого	621,000.00	3,339,881.00
120009	Бусад орлого	621,000.00	3,339,881.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,818,738,695.88	25,316,916,258.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,638,667,525.88	24,072,455,373.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,036,174,200.00	12,808,816,800.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,874,000.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,599,619,325.88	11,263,638,573.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,071,170.00	1,244,460,885.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	114,622,280.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУ-ын байгууллага	174,631,670.00	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	104,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	-	1,022,478,605.31
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,439,500.00	3,260,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	13,324,722,128.29	13,560,803,338.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,324,722,128.29	13,560,803,338.54
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,790,308,922.28	8,349,004,594.88
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,413,807,304.42	2,254,534,422.42
210101	Үндсэн цалин	1,590,938,278.62	1,374,180,886.93
210102	Нэмэгдэл	489,527,037.80	627,080,667.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	163,021,230.00	253,272,868.00
210105	Гэрээт ажлын хөлс	170,320,758.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,237,135.61	272,296,011.28
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	285,237,135.61	257,994,677.75
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	14,301,333.53
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	201,694,535.01	170,679,025.80
210301	Гэрэл цахилгааны зардал	89,042,511.01	113,674,645.80
210302	Түлш, халаалтын зардал	40,087,231.00	29,665,664.00
210303	Цэвэр, бохир усны зардал	9,114,793.00	7,573,466.00
210304	Байрны түрээс	63,450,000.00	19,765,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	109,829,909.10	140,762,363.80
210401	Бичиг хэрэг	50,280,170.00	62,519,250.00
210402	Тээвэр, шатахуун	22,448,240.00	25,025,903.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,004,999.10	33,983,955.00

Сангийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,096,500.00	19,233,255.00
2105	Нормативт зардал	40,400.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,673,180.00	260,276,845.40
210601	Багаж техник хэрэгсэл	-	25,259,003.40
210604	Урсгал засвар	11,673,180.00	235,017,842.00
2107	Томилолт, зочны зардал	133,082,496.04	64,537,121.00
210702	Дотоод албан томилолт	76,162,400.95	31,644,169.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	56,920,095.09	32,892,952.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,624,246,572.87	4,499,640,961.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,619,591,932.87	4,282,037,453.38
210803	Даатгалын үйлчилгээ	1,651,820.00	5,364,429.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	483,820.00	571,833.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,475,000.00	211,439,942.10
210807	Газрын төлбөр	-	106,304.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,010,697,389.23	686,277,843.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,882,986,639.23	686,277,843.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	127,710,750.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,534,413,206.01	5,211,798,743.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	623,606,615.96	2,100,552,808.66
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	623,606,615.96	2,100,552,808.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	184,040,537.00	343,329,338.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	128,240,537.00	145,829,338.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	55,800,000.00	197,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,726,766,053.05	2,767,916,597.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,726,766,053.05	2,767,916,597.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,494,637,567.59	11,759,452,800.77
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,982,161,324.17	11,759,452,800.77
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,982,161,324.17	11,759,452,800.77
2200	Дотоод эх үүсвэрээр	3,982,161,324.17	11,759,452,800.77
220001	Барилга байгууламж	1,599,619,325.88	11,263,638,573.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,382,541,998.29	495,814,227.77
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,982,161,324.17	-11,759,452,800.77
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ	2,512,476,243.42	-
230001	Эргэж төлөгдөх зээл	2,512,476,243.42	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-2,512,476,243.42	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	600,858,173.10	6,608,905,404.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,069,510,247.60	1,069,510,247.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	1,670,368,420.70	7,678,415,651.73
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			3,148,442,252.58	3,148,442,252.58
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	4,818,810,673.28	10,826,857,904.31
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	4,818,810,673.28	10,826,857,904.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	4,818,810,673.28	10,826,857,904.31
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		3,309,797,952.30		3,309,797,952.30
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	19,557,520.00			19,557,520.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			2,598,939,111.89	2,598,939,111.89
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,952,641,607.17	3,384,761,096.16	7,417,749,785.17	16,755,152,488.50

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,464,319,900.00	10,959,337,145.35	3,504,982,754.65	75.77
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	14,464,319,900.00	10,959,337,145.35	3,504,982,754.65	75.77
Бараа, үйлчилгээний зардал	12,034,970,000.00	8,715,828,998.69	3,322,015,001.31	72.42
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,725,146,300.00	2,254,534,422.42	470,611,877.58	82.73
Үндсэн цалин	1,513,673,800.00	1,374,180,886.93	139,492,913.07	90.78
Нэмэгдэл	694,200,100.00	627,080,667.49	67,119,432.51	90.33
Унаа, болон бусад нөхөн олговор	269,274,000.00	253,272,868.00	16,001,132.00	94.06
Гэрээт ажлын хөлс	247,998,400.00	-	247,998,400.00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,017,400.00	272,296,011.28	54,721,388.72	83.27
Тэтгэврийн даатгал	258,011,600.00	257,994,677.75	16,922.25	99.99
Тэтгэмжийн даатгал	27,251,400.00	14,301,333.53	12,950,066.47	52.48
ҮОМШӨ ний даатгал	21,801,100.00	-	21,801,100.00	-
Ажилгүйдлийн даатгал	5,450,300.00	-	5,450,300.00	-
Эрүүл мэндийн даатгал	14,503,000.00	-	14,503,000.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,710,200.00	170,679,025.80	24,031,174.20	87.66
Гэрэл цахилгаан	117,396,900.00	113,674,645.80	3,722,254.20	96.83
Түлш, халаалт	45,157,400.00	29,665,664.00	15,491,736.00	65.69
Цэвэр, бохир ус	11,555,900.00	7,573,466.00	3,982,434.00	65.54
Байрны түрээс	20,600,000.00	19,765,250.00	834,750.00	95.95
Хангамж, бараа материалын зардал	168,509,400.00	154,884,537.80	13,624,862.20	91.91
Бичиг хэрэг	66,087,000.00	64,499,250.00	1,587,750.00	97.60
Тээвэр (шатахуун)	35,148,000.00	25,025,903.80	10,122,096.20	71.20
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	35,427,400.00	33,983,955.00	1,443,445.00	95.93
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	31,847,000.00	31,375,429.00	471,571.00	98.52
Нормативт зардал	990,000.00	-	990,000.00	-
Нормын хувцас зөөлөн эдлэл	990,000.00	-	990,000.00	-
Эд хогшил худалдан авах	805,500,000.00	492,686,264.40	312,813,735.60	61.17
Багаж, техник, хэрэгсэл	294,000,000.00	257,668,422.40	36,331,577.60	87.64
Урсгал засвар	511,500,000.00	235,017,842.00	276,482,158.00	45.95
Томилолт, зочны зардал	87,841,300.00	64,537,121.00	23,304,179.00	73.47
Дотоод албан томилолт	50,183,300.00	31,644,169.00	18,539,131.00	63.06
Зочин төлөөлөгч хүлээн авах	37,658,000.00	32,892,952.00	4,765,048.00	87.35
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,603,612,500.00	4,743,941,966.25	859,670,533.75	84.66
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,115,718,400.00	4,471,951,958.15	643,766,441.85	87.42
Даатгалын үйлчилгээ	6,000,000.00	5,364,429.00	635,571.00	89.41
Тээврийн хэрэгслийн татвар	726,800.00	571,833.00	154,967.00	78.68
Тээврийн хэрэгслийн оношилгоо	122,000.00	121,000.00	1,000.00	99.18
Мэдээллийн технологийн зардал	480,938,900.00	265,826,442.10	215,112,457.90	55.27

Газрын төлбөр	106,400.00	106,304.00	96.00	99.91
Бараа үйлчилгээний бусад зардал	2,121,642,900.00	559,395,649.74	1,562,247,250.26	26.37
Бараа үйлчилгээний бусад зардал	2,121,642,900.00	565,143,649.74	1,556,499,250.26	26.64
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,429,349,900.00	2,246,382,146.66	182,967,753.34	92.47
Засгийн газар хоорондын шилжүүлэг	2,268,874,900.00	2,100,552,808.66	168,322,091.34	92.58
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,268,874,900.00	2,100,552,808.66	168,322,091.34	92.58
Бусад урсгал шилжүүлэг	160,475,000.00	145,829,338.00	14,645,662.00	90.87
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	160,475,000.00	145,829,338.00	14,645,662.00	90.87
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,464,319,900.00	10,959,337,145.35	3,504,982,754.65	75.76
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,464,319,900.00	10,958,871,264.35	3,505,448,635.65	75.76
Улсын төсвөөс санхүүжих	14,464,319,900.00	10,958,871,264.35	3,505,448,635.65	75.76
Бусад орлого		465,881.00	-465,881.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	167.00	167.00	-	100.00
Удирдах ажилтан	30.00	30.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	126.00	126.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-	100.00

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,244,460,885.31
УРСГАЛ ЗАРДАЛ		1,244,460,885.31
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		128,989,823.96
Бараа үйлчилгээний бусад зардал		128,989,823.96
Бараа үйлчилгээний бусад зардал		128,989,823.96
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,115,471,061.35
Бусад урсгал шилжүүлэг		197,500,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		197,500,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		917,971,061.35
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		917,971,061.35
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,244,460,885.31
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,244,460,885.31
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		114,622,280.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		104,100,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,022,478,605.31
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,260,000.00

Хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр: Сангийн яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/179/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Сангийн яам	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Хэрэгцээ шаардлага хангахгүй болсон хангамжийн материалыг байгууллагын удирдлагын тушаалгүйгээр данс бүртгэлээс хассан	17,789.6	Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	Б.Мягмарсүрэн
2	Гадаад томилолтын зардлаас ерөнхий сайдын албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд ороогүй 2 сэтгүүлчийн зардлыг тушаал шийдвэргүйгээр зарцуулсан	1,314.7	Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	Б.Мягмарсүрэн
	Дүн	19,104.3			